

УЛААНБААТАР ХОТОД ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА ЭРХЭЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ ҚОРОНАВИРУС ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Г.Мөнхбаясгалан*, **Т.Мөнх-Эрдэнэ****, **Н.Отгонсайхан*****,
Ж.Тунгалаг****

Хураангуй: Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд, том хэмжээтэй 345 жижиглэн худалдааны аж ахуйн нэгж, байгууллагууд судалгаанд хамрагдсан.

Дэлхий нийтэд 2019 оноос эхэлж тархсан коронавирус цар тахал нь жижиглэн худалдааны аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд сөрөг, эерэг байдлаар нөлөөлж байна.

Хүнсний биш барааны жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаа тасалдаж, борлуулалтын орлого эрс буурсан бол хүнсний худалдаа эрхлэгчдийн борлуулалтын орлого нэмэгдсэн. Мөн жижиглэн худалдааны аж ахуйн нэгж, байгууллагууд цар тахлын нөлөөллөөр дижитал шилжилт хийж эхэлжээ.

Түлхүүр үгс: жижиглэн худалдаа, онлайн дэлгүүр, борлуулалт, цар тахал

THE IMPACT OF CORONAVIRUS PANDEMIC ON RETAIL BUSINESS IN ULAANBAATAR

Abstract: Purpose of this study is to determine the impact of coronavirus pandemic on the retail business in Ulaanbaatar, Mongolia.

The survey conducted 345 small, medium, and large retailers in six central districts of Ulaanbaatar.

Coronavirus pandemic had negative and positive impacts on the activities of retail businesses. Non-food retailers disrupted operations and sales revenues declined sharply, while food retailers' sales revenues increased. And, retailers have begun to make the digital transition as a result of the pandemic.

Keywords: Retailing, online shop, sales, pandemic

* ХҮИС, (E-mail): munkhbayasgalan@nucb.edu.mn, <http://orcid.org/0000-0003-2424-2576>

** ХҮИС, (E-mail): munkherdene@nucb.edu.mn, <http://orcid.org/0000-0002-1041-9740>

*** ХҮИС, (E-mail): otgonsaikhan@nucb.edu.mn

**** ХҮИС, (E-mail): tungalag@nucb.edu.mn, <http://orcid.org/0000-0002-8979-1464>

Удиртгал

Бөөний болон жижиглэн худалдааны салбар нь 2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-ийн 14.7 хувийг бүрдүүлж буй бөгөөд тус салбарт нийт ажиллах хүчний 15 орчим хувь буюу 166.6 мянган хүн ажиллаж байна.

ДНБ-д бөөний болон жижиглэн худалдааны салбарын эзлэх хувь 2019 оноос 1.8 хувиар, нийт борлуулалт нь 1596.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Эдгээр үзүүлэлт 2016-2019 онуудад жил бүр өсөлттэй байсан бөгөөд 2020 онд ингэж буурсан нь дэлхий нийтийг хамарсан коронавирус цар тахлын нөлөөлөл байх магадлалтай.

Улс орны эдийн засаг, худалдааны салбар, худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд коронавирус цар тахал хэрхэн нөлөөлж буйг судалсан судалгааны ажлууд 2020 оны эхний улирлаас хийгдэж эхэлсэн байна. Эдгээр судалгааг хийхдээ богино, урт хугацаанд цар тахлын улмаас үүсэх нөхцөл байдал улс орны эдийн засаг, худалдааны салбар, жижиглэн худалдаа эрхлэгчид болон глобал нийлүүлэлтийн сүлжээнд үзүүлэх нөлөөллийг судалжээ.

Коронавирус цар тахал дэлхий дахинд тархаж эхэлсэн эхний саруудад улс орнууд хилээ хааж, дотооддоо хөл хорио тогтоосон зэргээс үүдэн эдийн засагт сөрөг нөлөөлөл гарч эхэлсэн байна. Тухайлбал, Fernandes (2020) 2020 онд хөл хорио тогтоосноос ихэнх улс орны ДНБ нь 3-5 хувиар буурч, аялал жуулчлал, зочид буудал, жижиглэнгийн худалдаа зэрэг үйлчилгээний салбарт хүнд цохилт учрах төлөвтэй гэсэн тооцоог хийжээ.

Гэхдээ цар тахал хүнсний дэлгүүрийн борлуулалтад харьцангуй бага нөлөөлсөн бол чухал шаардлагатай бус хувцас, цахилгаан бараа гэх мэт зарим барааны дэлгүүрийн борлуулалтад хүчтэй сөрөг нөлөөллийг үзүүлсэн байна. Жишээ нь, АНУ-д хувцасны дэлгүүрийн борлуулалт 2020 оны дөрөвдүгээр сард коронавирус цар тахлын нөлөөгөөр 1.74 тэрбум ам.доллар болж буурсан бол 2021 оны есдүгээр сард 15.9 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх сараас 1.4 тэрбум орчмоор буурсан дүнтэй байна⁵. Мөн Энэтхэг улсын хүнсний бус дэлгүүрүүдийн борлуулалтын орлого 2020 оны 3 сарын байдлаар 75 хувиар буурсан байна (Amgad et al., 2020).

Судлаачдын мэдэгдэж буйгаар коронавирус цар тахал дэгдэхээс өмнө дэлхийн 2-р дайнаас хойш олон улс орныг хамарсан ийм хатуу хязгаарлалт тогтоож байгаагүй аж. Хөл хорио, хязгаарлалтууд хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн өдөр тутмын амьдралд ноцтой нөлөөлж, яаралтай худалдан авалт хийх нөхцөл байдалд хүргэсэн нь жижиглэн худалдааны байгууллагуудад зарим сорилтыг бий болгосон. Цар тахлын улмаас бий болсон хориг хязгаарлалтууд нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нөлөөлж, барааг нөөцлөх, дэлгүүрт орохын

тул удаан хугацаагаар хүлээх, бөөгнөрөл үүсгэх гэх мэт үйлдлийг хийхэд хүргэсэн. Жижиглэн худалдаачид хүнс барааны хангалттай нөөц байгаа талаар мэдэгдэл гаргах, онлайн худалдаа, үйлчилгээний хэлбэрийг санал болгох, хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулах гэх мэт ажлуудыг хийсэн боловч зарим хэрэглэгчдэд энэ нь хангалтгүй санагдаж “panic buying” хийсээр л байв.

Цар тахлын улмаас улс орнууд хилээ хааж, бараа тээвэрт халдварт өвчний тархалтаас урьдчлан сэргийлэх ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, шалгууруудыг тавих болсноор улс хооронд ачаа тээвэрлэх үйл ажиллагааг удаашруулж, глобал нийлүүлэлтийн сүлжээ доголдож эхэлсэн. Chowdhury et al (2020) COVID-19 цар тахал нь дэлхийн эдийн засагт том үр дагавар, нөлөөллийг үзүүлсэн, ялангуяа цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг нийлүүлэлтийн сөрөг нөөцтэй тулгараад байгаа нь үйлдвэрлэл буурч, улмаар глобал нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулахад хүргэсэн гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, цар тахлын улмаас улс хоорондын барааны худалдааны нийлүүлэлт, татан авалт доголдож эхэлсэн нь жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд тодорхой нөлөөллийг үзүүлж байна.

Манай улсын импорт 2020 онд өмнөх оноос 0.8 тэрбум, хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт 9937,63 мянган ам.доллараар тус тус буурчээ. Харин боловсруулах үйлдвэрлэл 14.1 хувиар өсөж, жижиглэн худалдааны борлуулалт 3452,1 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Хоёрдогч өгөгдлөөс харахад жижиглэн худалдааны борлуулалтад коронавирус цар тахал эерэг нөлөөлсөн мэт харагдаж байна, харин бусад үйл ажиллагаа, гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж буй талаар анхдагч өгөгдөл цуглуулсан судалгааны зарим үр дүнгээс энэ өгүүллээрээ уншигчидтай хуваалцахыг зорьлоо.

Судалгааны арга зүй, судалгааны өгөгдөл боловсруулалт

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт жижиглэн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд коронавирус цар тахлын үзүүлж буй нөлөөллийг судлах зорилгоор 2021 оны 10 сарын 10-ны өдрөөс 15 хоногийн хугацаанд судалгааны талбарт ажиллаж, 348 аж ахуйн нэгжээс өгөгдөл цуглуулсан. Гэвч судалгаанд оролцсон 3 аж ахуйн нэгжийн үндсэн байршил, харьяалал нь Төв аймаг, Налайх дүүргийнх байсан тул тэдгээрийг хасаж, үлдсэн 345 оролцогчдоос цуглуулсан өгөгдөлд шинжилгээ хийлээ.

Асуулга нь 4 үндсэн хэсгээс бүрдсэн нийт 15 асуулттай бөгөөд нэгдүгээр хэсэгт ерөнхий үйл ажиллагаан дахь нөлөөлөл, хоёрдугаар хэсэгт удирдлага зохион байгуулалт, хүний нөөц дэх нөлөөлөл, гуравдугаар хэсэгт маркетингийн

үйл ажиллагаан дахь нөлөөлөл, дөрөвдүгээр хэсэгт засгийн газрын дэмжлэгт хамрагдсан байдлыг тодруулах асуултыг асуусан болно. Энэ өгүүлэлд бид асуулгын нэгдүгээр хэсгийн үр дүнг голчлон оруулаа.

Судалгааны цуглуулсан өгөгдлийг SPSS26 програм дээр боловсруулан үр дүнг шинжлэв.

Энэ судалгааны ажлыг ХҮИС-ийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон жижиглэн худалдааны байгууллагуудын талаарх ерөнхий мэдээллийг Хүснэгт 1-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон жижиглэн худалдааны байгууллагуудын ерөнхий мэдээлэл

Дүүрэг	Ажилчдын тоо			Ангилал төрөл							Нийт
	<9	1-50	51-200	Хүнсний жижиг дэлгүүр	Супермаркет	Хайпермаркет	Хүнсний түрээсийн лангуу	Хүнсний биш барааны түрээсийн лангуу	Хүнсний биш барааны дэлгүүр	Онлайн дэлгүүр	
Чингэлтэй	67	5	1	13	7	0	8	33	6	6	73
Баянгол	85	9	1	30	7	4	1	10	13	30	95
Сонгинохайрхан	22	0	3	11	1	1	1	7	3	1	25
Хан-Уул	28	5	0	18	3	0	2	5	3	2	33
Сүхбаатар	27	5	1	24	5	0	0	2	2	0	33
Баянзүрх	67	8	11	32	3	1	18	14	10	8	85
Бүгд	296	32	17	128	26	6	30	71	37	47	345

Эх сурвалж: Улаанбаатар хотод жижиглэн худалдаа эрхэлж буй ААНБ-ын цйл ажиллагаанд Covid19 цар тахлын нөлөөллийн судалгаа 2021, ХҮИС, ХМТ

Манай улсын жижиглэн худалдааны газруудын дийлэнх нь жижиг, дунд хэмжээтэй аж ахуйн нэгж байдаг бөгөөд ихэвчлэн гэр бүлийн эзэмшилд үйл ажиллагаагаа явуулдаг нь статистик мэдээлэл, судалгааны үр дүнгээс харагддаг. Судалгаанд жижиг, дунд, том хэмжээтэй жижиглэн худалдааны

олон ангилалд хамаарагдах аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Судалгаанд оролцогчдоос тэдний байгууллагын үйл ажиллагаанд коронавирус цар тахал хэрхэн нөлөөлсөн талаар асууж, Лайкертын 1-5 гэсэн хэмжээсээр үнэлүүлсэн. Энд 1 санал огт нийлэхгүй, 5 санал бүрэн нийлнэ гэсэн утгатай.

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон жижиглэн худалдааны аж ахуйн нэгжийн үйл ажиллагаан дахь коронавирус цар тахлын нөлөөллийн үнэлгээ

Асуулт	Лайкер хэмжээс					Дундаж үнэлгээ
	1	2	3	4	5	
Бизнесийн үйл ажиллагаа тасалдсан	66	19	32	40	188	3.8
Борлуулалт нэмэгдсэн	115	56	79	43	52	2.6
Зардал буурсан	136	75	71	26	37	2.3
Ашиг нэмэгдсэн	122	62	78	37	46	2.5
Ажилчдын тоо буурсан	152	35	69	43	46	2.3
Нийлүүлэлт саатсан	42	27	45	73	158	3.8
Нэг удаад татан авах барааны тоо хэмжээ нэмэгдсэн	77	53	64	55	96	3.1
Бизнесээ шинэчлэх боломж олгосон	138	77	57	26	47	2.3
Утсаар захиалга авч, захиалсан барааг нь хүргэж өгдөг болсон	123	18	29	44	131	3.1

Эх сурвалж: Улаанбаатар хотод жижиглэн худалдаа эрхэлж буй ААНБ-ын үйл ажиллагаанд Covid19 цар тахлын нөлөөллийн судалгаа 2021, ХҮИС, ХМТ

Хүснэгт 2-оос харахад коронавирус цар тахлын улмаас судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тасалдсан (дундаж утга 3.8) байна. Үйл ажиллагаа тасалдах үндсэн шалтгаан нь хатуу хөл хорио тогтоосон, дэлгүүрийн ажиллах цагийг хязгаарласан гэх мэт байх бөгөөд судалгаанд оролцсон хүнсний биш барааны дэлгүүрийн 85.9, хүнсний биш түрээсийн лангууны 95.6 хувь нь үйл ажиллагаа тасалдсан гэсэн хариултыг өгчээ. Гэтэл хүнсний жижиг дэлгүүрийн 28.9, супермаркетийн 38.5, хайпермаркетын 83.3, онлайн

дэлгүүрийн 61.7 хувь нь борлуулалт нэмэгдсэн гэсэн хариултыг сонгосон байна.

Хүнсний биш барааны дэлгүүрийн үйл ажиллагаа тасалдсан 85.9-95.6, хүнсний дэлгүүрийн орлого нэмэгдсэн 28.9-83.3 хувь байгаа нь цар тахал хүнсний дэлгүүрийн борлуулалтад харьцангуй бага нөлөөлсөн бол чухал шаардлагатай бус хувцас, цахилгаан бараа гэх мэт зарим барааны дэлгүүрийн борлуулалтад хүчтэй сөрөг нөлөөллийг үзүүлсэн гэсэн дэлхий нийтийн чиг хандлагатай нийцэж байна.

Судалгаанаас жижиглэн худалдааны аж ахуйн нэгжийн зардал, ашиг буурч, ажилчдын тоо багасаагүй гэсэн үр дүн гарч байна. Ажилчдын тоо буурсан гэж 25.2 хувь хариулснаас харахад судалгаанд оролцсон 4 аж ахуйн нэгж тутмын ажилчдын тоо тодорхой хэмжээгээр буурсан байна. Харин Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр судалгааны өгөгдөл цуглуулсан 2021 оны 3 улиралд Улаанбаатар хотын жижиглэн худалдааны салбарт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 7958 хүнээр буурчээ.


Дэлхий даяар тархсан коронавирус цар тахлаас улбаалан глобал нийлүүлэлтийн сүлжээ доголдсон асуудал гарсан. Өнөөдрийн байдлаар энэ асуудал манай улсын ачаа бараа тээврийн болон бизнесийн байгууллагын өмнө тулгарч буй гол бэрхшээл, сорилт болж байна. Энэ бэрхшээл, сорилт нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй жижиглэн худалдааны аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлж буйг тодруулах асуултыг асуусан. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүд барааны нийлүүлэлт саатсан (дундаж утга 3.8) гэж хариулсан бөгөөд тэдний 43.8 хувь нь нэг удаад татан авах барааны тоо хэмжээ нэмэгдсэн гэж хариулсан байна. Нэг удаад татан авах барааны тоо хэмжээ нэмэгдсэн гэсэн хариултыг жижиглэн худалдааны төрлөөр нь нарийвчлан үзвэл:

- Хайпермаркетийн 66.7 хувь
- Хүнсний жижиг дэлгүүрийн 55.5 хувь
- Онлайн дэлгүүрийн 53.2 хувь
- Супермаркетийн 50.0 хувь
- Хүнсний биш барааны дэлгүүрийн 35.1 хувь
- Хүнсний биш барааны лангуу түрээслэгчдийн 25.4 хувь
- Хүнсний барааны лангуу түрээслэгчдийн 23.3 хувь нь өмнөхөөс ахиу хэмжээгээр нэг удаад барааны нөөцөө бүрдүүлэх болсон байна.

Дэлхийн бусад орнуудад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад цар тахлын улмаас бизнесийн байгууллагууд үйл ажиллагаа, бизнес моделио шинэчлэх, оффисын ажилтнуудын ажлын цагийн хуваарийг уян хатан болгох

зэргээр зарим өөрчлөлтийг хийж эхэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 21.1 хувь нь л коронавирус цар тахал бизнесээ шинэчлэх боломж олгосон гэж хариулсан байх бөгөөд энэ асуултад хариулсан байдлыг жижиглэн худалдааны төрөл, ажилчдынх нь тооноос хамааруулан (Зураг 1, Зураг 2) авч үзсэн.



Эх сурвалж: Улаанбаатар хотод жижиглэн худалдаа эрхэлж буй ААНБ-ын үйл ажиллагаанд Covid 19 цар тахлын нөлөөллийн судалгаа 2021, ХУИС, ХМТ

Хүнсний биш барааны дэлгүүр, лангуу, хүнсний барааны лангуу түрээслэгчдийн үйл ажиллагаа нь цар тахлын улмаас тасалдаж, борлуулалт огцом буурсан гэх зэрэг шалтгааны улмаас бизнесээ шинэчлэх шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүрсэн бололтой. Харин цар тахлын улмаас бизнесээ өөрчлөх хэрэгцээгээ мэдэрсэн байдал нь судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн том, жижгээс (ажилчдын тоо) үл хамаарч байна.

Коронавирус цар тахлын тархалтын улмаас 2020 онд нийслэлд хэд хэдэн удаа хатуу хөл хорио тогтоож, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хязгаарлах, худалдааны газруудын ажлын цагт зохицуулалт хийх, архи согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглох зэрэг ажлууд хийгдсэн. Энэ үед хүнсний барааны жижиглэн худалдаа эрхлэгчид үйл ажиллагааны хязгаарлалтад хамрагдаагүй боловч хөл хорио, зарим айл өрхүүд зарим хүнс, барааг хөл хорионоос өмнө нөөцөлж авсан, хэрэглэгчид зарим чухал биш барааны худалдан авалтыг тэвчих гэх мэт шалтгаанаас борлуулалтын орлого нь буурах хандлагатай болсон.

Харин хүнсний биш барааны дэлгүүр, лангуу түрээслэгчдийн хувьд үйл ажиллагааны хязгаарлалтад орсон, хатуу хөл хорионы улмаас зарим улирлын шинжтэй барааны улирал нь өнгөрсөн, шинэ жил, цагаан сарын баярыг өргөн хүрээнд тэмдэглээгүй зэргээс мөн л борлуулалт тасалдах, огцом буурах гэх

мэт нөхцөл байдал үүссэн билээ.

Эдгээр нөхцөл байдлууд нь жижиглэн худалдаа эрхлэгчдийг үйл ажиллагаагаа тодорхой түвшинд өөрчлөх шаардлага үүссэний илэрхийлэл болжээ. Жижиглэн худалдаа эрхлэгчдийн хувьд нэн тэргүүнд хийж чадах үйл ажиллагааны өөрчлөлт бол барааг хэрэглэгчдийн хүссэн цагт хүссэн барааг нь худалдан борлуулах олон арга хэлбэрийг санал болгох юм. Энэ нь утсаар худалдан авагчдын худалдан авах барааны захиалгыг хүлээн авч, захиалсан барааг нь хүргэж өгөх болон цахим шилжилт хийх болно.

Цар тахлын үед цахим шилжилт хийж цахим худалдаа эрхэлдэг болсон эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 16.2 хувь нь цахим худалдааг цар тахлаас өмнө ч эрхэлж байсан, 38.0 хувь нь цар тахлын үед цахим худалдаа эрхэлж эхэлсэн гэжээ. Цахим шилжилт хийсэн байдлыг жижиглэн худалдааны төрлөөр нь авч үзвэл хүнсний жижиг дэлгүүр, хайпермаркет, хүнсний биш барааны дэлгүүр, лангуу түрээслэгчид илүү их цахим шилжилт хийсэн (Зураг 3) дүнгэй байна.



Эх сурвалж: Улаанбаатар хотод жижиглэн худалдаа эрхэлж буй ААНБ-ын цйл ажиллагаанд Covid19 цар тахлын нөлөөллийн судалгаа 2021, ХУИС, ХМТ

Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжийн 50.7 хувь нь цар тахлын үед тогтоосон хөл хорионы үеэс эхлэн хэрэглэгчдийн захиалгыг утсаар хүлээн авч, захиалсан барааг нь хүргэж өгөх үйлчилгээг нэвтрүүлсэн байна. Энэ үйлчилгээг

нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг ажилчдын тоо, жижиглэн худалдааны ангилал төрлөөр нь (Хүснэгт 3) нарийвчлан авч үзлээ. Дунд хэмжээтэй буюу 10-50 хүртэлх ажилчидтэй жижиглэн худалдааны байгууллагууд энэ үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хувь нь өндөр байхад судалгаанд оролцсон хайпермаркетуудын дийлэнх нь энэ үйлчилгээг үзүүлдэг байна.

Хүснэгт 3. Хэрэглэгчдийн захиалгыг утсаар хүлээн авч, захиалсан барааг нь хүргэж үйлчилгээг нэвтрүүлсэн жижиглэн худалдааны ААН-ийн тухайн ангилалд эзлэх хувь

Ангилал төрөл	Үйлчилгээг нэвтрүүлсэн ААН	
Хүнсний жижиг дэлгүүр	56.3	
Супермаркет	26.9	
Хайпермаркет	83.3	
Хүнсний түрээсийн лангуу	36.7	
Хүнсний биш барааны түрээсийн лангуу	23.9	
Хүнсний биш барааны дэлгүүр	51.4	
Онлайн дэлгүүр	93.6	
Нийт	50.7	
ААН-ийн ажилчдын тоо	Үйлчилгээг нэвтрүүлсэн ААН	
9 хүртэл	48.6	
10-50	71.9	
50-иас дээш	47.1	
Нийт	50.7	

Эх сурвалж: Улаанбаатар хотод жижиглэн худалдаа эрхэлж буй ААНБ-ын үйл ажиллагаанд Covid19 цар тахлын нөлөөллийн судалгаа 2021, ХУИС, ХМТ

Хэрэглэгчид, айл өрхүүдэд илүү ойр байрласан байдаг хүнсний жижиг дэлгүүрүүдийн талаас илүү хувь нь энэ үйлчилгээг үзүүлж байгаа нь хэрэглэгчдэд үйлчилгээгээ илүү ойртуулах, өрсөлдөөний давуу байдлыг олж авахад илүү нөлөөлсөн байх магадлалтай. Ихэнх онлайн буюу цахим дэлгүүрүүд цахим худалдаа эрхлэхээс гадна утсаар захиалга авах үйлчилгээтэй байна гэсэн үр дүн судалгаанаас харагдаж байна. Хэрэглэгчдийн бараа худалдан авах захиалгыг гар болон суурин утас, фейсбуук хуудас гэх мэт нийгмийн сүлжээ, цахим худалдааны вэб сайтаар хүлээн авч, хүргэлт хийх хэлбэрийг түгээмэл ашигласан бөгөөд эдгээр нь харьцангуй бага зардлаар богино хугацаанд

хуваарилалтын сувгаа өөрчлөх боломжийг жижиглэн худалдаачдад бүрдүүлсэн.

Дүгнэлт

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд, том хэмжээтэй 345 жижиглэн худалдааны аж ахуйн нэгж, байгууллагуудыг судалгаанд хамруулаа.

Бидний асуулгын нэгдүгээр хэсэг болох ерөнхий үйл ажиллагаан дахь нөлөөллийн судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл 2019 оноос эхэлж дэлхий нийтээр тархсан коронавирус цар тахал нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй жижиглэн худалдааны аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд тодорхой нөлөөлөл, ул мөрийг үлдээж байгаа нь харагдаж байна. Эдгээрийг тоймлон дурьдвал:

- Судалгааны ажлын эхэнд дэвшүүлсэн зорилгоо биелүүлж, коронавирус цар тахлын жижиглэн худалдааны аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөөллийг судалж, хүнсний барааны жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл бага, хүнсний биш барааны жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл их байгааг илрүүллээ. Мөн зарим жижигдлэн худалдаа эрхлэгчид үйл ажиллагаандаа шинэчлэл, дижитал шилжилт хийх, бизнесийн шинэ боломжийг эрэлхийлэх зэргээр эерэг нөлөөллийг үзүүлсэн байна.
- Хүнсний биш барааны дэлгүүрүүдийн борлуулалт буурсан боловч хүнсний жижиг дэлгүүр, супермаркет, хайпермаркет, онлайн дэлгүүрийн борлуулалт тодорхой хэмжээнд нэмэгдсэн.
- Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн барааны нийлүүлэлт бөгөөд тэдний 43.8 хувийнх нь нэг удаад татан авах барааны тоо хэмжээ нэмэгдсэн байна.
- Коронавирус цар тахлын улмаас үүсэж буй хүндрэл бэрхшээл, сорилт нь бизнесээ шинэчлэх боломж харж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо харьцангуй цөөн байна.
- Зарим жижиглэн худалдааны аж ахуйн нэгж, байгууллагууд борлуултыг нэмэгдүүлэх зорилгоор дижитал шилжилт хийх, хэрэглэгчдийн бараа худалдан авах захиалгыг хүлээн авч, захиалсан барааг нь хүргэж өгөх үйлчилгээг нэвтрүүлж эхэлжээ. Тухайлбал, судалгаанд 47 онлайн дэлгүүр оролцсон бөгөөд тэдний 43 хувь нь цар тахлын үед үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

- Цаашид жижиглэн худалдааны байгууллагын үйл ажиллагаан дахь коронавирус цар тахлын нөлөөллийн судалгааг цар тахлын тархалт хумигдаж, хэвийн амьдралд шилжсэн үетэй харьцуулсан судалгаа, зөвхөн хүнсний эсвэл хүнсний биш барааны жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаан дахь нөлөөллийн судалгаа, цар тахлын үе дэх онлайн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн судалгаа гэх мэтээр нарийвчилан хийх боломжтой байна.

Ашигласан материал

- Amgad S.D. Khaled, Nabil Mohamed Alabsy, Eissa A. Al-Homaidi & Abdulmalek M.M. Saeed. 2020. The impact of the COVID-19 pandemic on retailer performance: empirical evidence from India. *Innovative Marketing*, 16(4): 129-138. doi:[10.21511/im.16\(4\).2020.11](https://doi.org/10.21511/im.16(4).2020.11)
- Chowdhury, M., Sarkar, A., Paul, S.K. 2020. A case study on strategies to deal with the impacts of COVID-19 pandemic in the food and beverage industry. *Operation Management Research*, (Published Online 30 September 2020). <https://link.springer.com/content/pdf/10.1007/s12063-020-00166-9.pdf>
- Fernandes, Nuno, Economic Effects of Coronavirus Outbreak (COVID-19) on the World Economy.2020. IESE Business School Working Paper No. WP-1240-E, Available at SSRN: <https://ssrn.com/abstract=3557504> or <http://dx.doi.org/10.2139/ssrn.3557504>
- Pantano, E., Pizzi, G., Scarpi, D., & Dennis, C. 2020. Competing during a pandemic? Retailers' ups and downs during the COVID-19 outbreak. *Journal of business research*, 116:209–213. <https://doi.org/10.1016/j.jbusres.2020.05.036>
- Statista. 2021. Monthly retail sales of U.S. clothing stores from January 2017 to September 2021 <https://www.statista.com/statistics/289783/us-retail-apparel-store-sales-on-a-monthly-basis/>
- Үндэсний Статистикийн Хороо. 2021. Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл-2020. УБ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Yearbook2020.all_link..pdf&ln=Mn
- Үндэсний Статистикийн Хороо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://1212.mn/>